



Доктор, профессор Д. Санжжавын нэрэмжит “Сэтгэл судлаач мэргэжлийн үнэ цэн” VI олимпиад



БАТЛАВ: НССДС-ИЙН ЗАХИРАЛ Ч. БАЗАР Др. Ч.БАЗАР

СЭТГЭЛ СУДЛАЛЫН УХААНЫ ДОКТОР, ПРОФЕССОР Д.САНЖЖАВЫН НЭРЭМЖИТ “СЭТГЭЛ СУДЛААЧ МЭРГЭЖЛИЙН ҮНЭ ЦЭН” VI ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1994 онд Сэтгэл судлаач мэргэжлээр үндэсний мэргэжилтэн бэлтгэснээс хойш тасралтгүй 26 жил Сэтгэл судлал хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэн төгсгөж байгаа Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль Монголын сэтгэл судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүднээс энэхүү мэргэжлээр суралцаж буй оюутан суралцагчдын дунд Доктор, профессор Д.Санжжавын нэрэмжит “Сэтгэл судлаач мэргэжлийн үнэ цэн” олимпиадыг 6 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж байна.

Энэ удаагийн олимпиадыг суралцахуйн бэрхшээл /хөгжлийн бэрхшээлээс ангид асуудал гэдгийг анхаарах/-ийг тойрсон асуудлаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн болно. Тухайн хүний оюуны түвшнээс үл хамааран бүх насныханд суралцахуйн бэрхшээл тохиолдсоноос эмх цэгцгүй суралцдаг. Суралцахуйн бэрхшээл нь мэдрэхүйгээр хүлээн авсан мэдээллийг боловсруулах, амжилттай суралцахад саад учруулдаг. Улмаар нийгмийн сэтгэл зүйн олон асуудлыг үүсгэдэг. Асуудлыг шийдвэрлэхэд оюутан судлаачдын судалгаа, шинжилгээний ажил, дэвшүүлж буй арга зүй нь нийгмийн ач холбогдолтой учраас энэ удаагийн олимпиадыг “Суралцахуйн бэрхшээлд нөлөөлж буй хүчин зүйлс, түүний үр дагаврыг нийгмийн сэтгэл зүйн талаас судлан илрүүлэхэд оюутан судлаачдын оруулах хувь нэмэр” сэдвээр зохион байгуулж байна.

ХОЁР. ОЛИМПИАДЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Зорилго:

- Суралцахуйн бэрхшээл, түүнд нөлөөлөх хүчин зүйлс болон гарах үр дагаврыг олон талаас нь судлах, түүнтэй холбоотой нийгэмд үүсээд буй асуудлуудыг сэтгэл зүйн талаас нь шийдвэрлэх шийдлийг тодорхойлох.

Зорилт:

- Сэтгэл судлаач мэргэжилтэн болохоор зорьж буй оюутан-судлаачдын мэдлэг, чадвар, судалгаа шинжилгээний ажлыг хөхүүлэн дэмжих;
- Сэтгэл судлаачдын нэгдмэл, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршино.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

- ✓ Их, дээд сургуулийн “Сэтгэл судлал” хөтөлбөрөөр бакалаврын түвшинд суралцаж буй I-IV дамжааны оюутнууд оролцоно.

ДӨРӨВ. БҮТЭЭЛ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Олимпиадыг хоёр үе шаттай зохион байгуулна.

Нэгдүгээр шат: “Суралцахуйн бэрхшээлд нөлөөлж буй хүчин зүйлс, түүний үр дагаврыг нийгмийн сэтгэл зүйн талаас судлан илрүүлэхэд оюутан судлаачдын оруулах хувь нэмэр” сэдвийн хүрээнд эсээ бичнэ. Үгийн тоо 1500-2000.



Доктор, профессор Д. Санжжавын нэрэмжит “Сэтгэл судлаач мэргэжлийн үнэ цэн” VI олимпиад

Судалгаа хийх, эсээ бичих хугацаа: 2022 оны 10 дугаар сарын 10-аас 11 дүгээр сарын 10 хүртэл

Материалыг хүлээж авах сүүлийн өдөр: 2022 оны 11 дүгээр сарын 10

Хоёрдугаар шат: Ирсэн бүтээлүүдээс шилдэг 20 эсээ шалгаруулж, 2-р шатанд оролцох эрхийг олгоно. 2-р шатанд оролцох эрх авсан 20 оролцогч 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр эсээгээ хэлэлцүүлж, “Сэтгэл зүйн бодлого, дасгал” гүйцэтгэж онолын болон практик мэдлэг чадвараа сорино.

ТАВ. ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нийтлэг шаардлага:

1. Эрдэм шинжилгээний эсээний үндсэн загварын дагуу бичнэ.
2. Баримт нотолгоонд суурилсан байна.
3. Шийдлийн хувилбаруудыг боловсруулсан байна.
4. Удирдан чиглүүлэгч багштай байна.
5. Оюутны тодорхойлолт хавсаргана.

Техникийн шаардлага:

1. Илтгэл нь Windows Microsoft Office програм дээр (.docx) өргөтгөлтэй хийгдсэн байна.
2. Илтгэлийн ерөнхий гарчиг нь 14pt хэмжээтэй Bold, ТОМ ҮСГЭЭР, Дэд гарчгууд нь 12pt үсгийн хэмжээтэй Bold форматтай, Бичвэрийн үсгийн фонт- [Times new roman, 12pt, мөр хоорондын зай1, баруун зүүн талаасаа зэрэгцсэн байна]
3. Цаасны хэмжээ: Top:2.5 см, Bottom:2 см, Left:3 см, Right:2см
4. Ишлэл, эх сурвалж, ном зүйн бичилтийг олон улсын АРА форматын дагуу бичнэ.
5. Итгэл тавихдаа PPT форматаар бэлтгэнэ.

ЗУРГАА. ШАГНАЛ

ТЭРГҮҮН БАЙР- 1 (Цом, Өргөмжлөл, 250 000 төгрөг)

ДЭД БАЙР- 1 (Өргөмжлөл, 150 000 төгрөг)

ГУТГААР БАЙР – 1 (Өргөмжлөл, 100 000 төгрөг)

ТУСГАЙ БАЙР- 1 (Өргөмжлөл, дурсгалын зүйлс)

ШИЛДЭГ УДИРДАГЧ БАГШ-1 (Өргөмжлөл, дурсгалын зүйлс)

Эрдэм шинжилгээний эсээг info@usp.mn хаягаар 2022 оны 11 дугаар сарын 10-ны дотор илгээх ба Subject хэсэгт оролцогч өөрийн нэр, хаяг, утасны дугаараа тодорхой бичнэ.

Нэмэлт мэдээлэл авах утас: 70142511, 90862222

**НИЙГЭМ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛ
СЭТГЭЛ СУДЛАЛ, НИЙГМИЙН АЖЛЫН ТЭНХИМ.**

2022.10.07